

ГУЧИН-УС СУМЫН 2025-2035 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

Гучин-Ус сумын 2025-2035 оны стратеги боловсруулах техникийн үзүүлэлт:

Монгол Улсын “Алсын хараа 2050” хөгжлийн баримт бичгийг хөгжлийн хөтчөө болгон хөрш залгаа сумд, Говийн бүсийн хэмжээнд дэлхийн бусад орны эдийн засгийн интеграци, коридортой холбогдон хөгжиж, стратегийн хөгжлийн төв хотууд бүс нутгийн байгаль экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй, ногоон эдийн засаг, дэвшилтэт технологид суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ, эрчимжсэн мал ах ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл, эрдэс баялгийн үйлдвэрлэл, аж үйлдвэр, үйлчилгээ, аялал жуулчлал, соёл, боловсрол, шинжлэх ухаан, тээвэр логистик, дэд бүтэц, кластерын төв зэрэг олон талаас нь судалж, хүний нөөц, ажилгүйдлийг бууруулж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломж, арга замыг тодорхойлон, хүн амын тоог нэмэгдүүлэх үндэслэлтэй сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулсан байна.

Өвөрхангай аймгийн 2034 он хүртэлх бодлогын бичиг баримтуудтай уялдуулах

- Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Өвөрхангай аймгийн хөгжлийн төлөвлөгөө

Өвөрхангай аймгийн эдийн засгийн хөгжлийн хэтийн төлвийг судалж, уялдуулсан байна.

Сумын өнөөгийн нөхцөл байдалд Swot шинжилгээ хийсэн байх

Сумын зах зээлийн багтаамж, нөөц боломжид тулгуурлан эдийн засгийн хөгжлийн загварчлалыг судалсан байх

Гучин-Ус сум нь Өвөрхангай аймгийн эдийн засгийн 5 дугаар бичил бүсэд багтдаг бөгөөд сумын байгаль, нутаг дэвсгэрийн нөхцөл, нөөц, нийгэм эдийн засгийн одоогийн байдал болон хэрэгцээт байдал, хөгжлийн бодлого хэтийн төлөв зэрэгтэй уялдуудсан байх

Бүс нутгийн онцлогт тулгуурласан дэд бүтэц, тээвэр-логистикийг хөгжүүлэх арга хэлбэрийг судалсан байх

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болох

Сумын нийгэм, соёлын онцлог, нөөцөд тулгуурласан, хөгжүүлэх нэн шаардлагатай брэнд бүтээгдэхүүний төрлүүдийг тодорхойлсон байх